

БАТЛАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ
СУМЫН ЗАСАГ ДАРГА

 Б.СЭРГЭЛЭН/

2024 оны 02 сарын 19

“БТЕГ” ХХК-ИЙН БАЯНГОЛ УУРХАЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

 Ж.МӨНХБААТАР/

2024 оны 02 сарын 19

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ,
ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ АСУУДЛААР ХАМТРАН
АЖИЛЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

№ 001

Энэхүү гэрээг нэг талаас Сэлэнгэ аймаг Ерөө сумын Засаг дарга (цаашид Засаг дарга гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Болд Төмөр Ерөө гол” ХХК (цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх), нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Сэлэнгэ аймгийн Ерөө суманд байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2-р багийн нутагт ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

1.3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй энэхүү гэрээг тухайн сумын Засаг дарга байгуулна.

Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэн, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

2.1.2 Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгөх;

2.1.3 Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээллэх;

2.1.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг орон нутгийн иргэдэд ил тод нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

2.1.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих,

2.1.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт шаардлалгыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж зохих хариуг цаг хугацаанд нь өгөх;

2.1.7 Сум орон нутгийн төсвийн байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх;

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1 Үйл ажиллагаагаа хэвийн тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг мэргэжил олгох сургалтад хамруулах талаар сумын хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

3.1.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа болон гэрээний хэрэгжилтийн талаар сумын иргэдэд жилд хоёроос доошгүй удаа мэдээлэл өгч ажиллах;

3.1.4 Бараа худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутаг бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох;

3.1.5 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалахад ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

3.1.6 Онцгой нөхцөл байдлын /гамшгийн/ үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;

3.1.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боломжит бүсэд нутгийн малчин иргэд зусах, өвс хадлан бэлтгэх боломжийг бүрдүүлэх;

3.1.8 Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг орон нутгийн төрийн захиргааны байгууллагатай хамтран хоёр талын саналыг зөвшилцөн тэмдэглэн өнгөрүүлэх;

3.1.9 Сумын Засаг дарга болон Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх;

3.1.10 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийт ажиллагсадын тодорхой хувийг сумын иргэдээс бүрдүүлэх;

3.1.11 Орон нутгийн иргэдийг уурхайн дотоод дүрэм журам болон түүнд нийцүүлэн гаргасан дагалдаж журамд заасан хувиарт цагаар саадгүй дамжин өнгөрөх нөхцөл боломжоор хангах;

3.1.12 Ерөө суманд спорт заал барих ажлыг хийж гүйцэтгэх

Дөрөв. Гэрээний хэрэгжилт

4.1 Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 02 дугаар сарын 01-ний дотор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлнэ.

4.2. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Тав. Гэрээний хариуцлага

5.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

5.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1 Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

Долоо. Гэрээ хүчин төгөлдөр болох

7.1 Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 /нэг/ жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

7.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байна.

7.4 Гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

АШИГТ МАЛТМАЛЫН
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

СЭЛЭНГЭ АЙМАГ ЕРӨӨ СУМЫН

“БТЕГ” ХХК-ИЙН БАЯНГОЛ УУРХАЙН

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА


БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА


...../С.ЦЭВЭЛМАА/


...../Г.АРИУНТУЯА/

БАТЛАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ
СУМЫН ЗАСАГ ДАРГА


Б.Сэргэлэн
Б.СЭРГЭЛЭН/
2024 оны 02 сарын 19

“ИНФИНИТИ СПЕЙС” ХХК-ИЙН
ХАНДГАЙТ УУРХАЙН

LLC ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.Золзаяа
/Б.ЗОЛЗАЯА/
2024 оны 02 сарын 19

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ,
ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ АСУУДЛААР ХАМТРАН
АЖИЛЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ
№ 002.**

Энэхүү гэрээг нэг талаас Сэлэнгэ аймаг Ерөө сумын Засаг дарга (цаашид Засаг дарга гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Инфинити Спейс” ХХК (цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх), нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцлөөр харилцан тохиролцож 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Сэлэнгэ аймгийн Ерөө суманд байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2-р багийн нутагт ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

1.3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй энэхүү гэрээг тухайн сумын Засаг дарга байгуулна.

Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэн, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

2.1.2 Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгөх;

2.1.3 Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээллэх;

2.1.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг орон нутгийн иргэдэд ил тод нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

2.1.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих;

2.1.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт шаардлалгыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж зохих хариуг цаг хугацаанд нь өгөх;

2.1.7 Сум орон нутгийн төсвийн байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх;

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1 Үйл ажиллагаагаа хэвийн тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг мэргэжил олгох сургалтад хамруулах талаар сумын хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

3.1.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа болон гэрээний хэрэгжилтийн талаар сумын иргэдэд жилд хоёроос доошгүй удаа мэдээлэл өгч ажиллах;

3.1.4 Бараа худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох;

3.1.5 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалахад ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

3.1.6 Онцгой нөхцөл байдлын /гамшгийн/ үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;

3.1.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боломжит бүсэд нутгийн малчин иргэд зусах, өвс хадлан бэлтгэх боломжийг бүрдүүлэх;

3.1.8 Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг орон нутгийн төрийн захиргааны байгууллагатай хамтран хоёр талын саналыг зөвшилцөн тэмдэглэн өнгөрүүлэх;

3.1.9 Сумын Засаг дарга болон Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх;

3.1.10 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийт ажиллагсадын тодорхой хувийг сумын иргэдээс бүрдүүлэх;

3.1.11 Орон нутгийн иргэдийг уурхайн дотоод дүрэм, журам болон түүнд нийцүүлэн гаргасан дагалдаж журамд заасан хуваарьт цагаар саадгүй дамжин өнгөрөх нөхцөл боломжоор хангах;

3.1.12 Сумын иргэдийг ажилд авахдаа сум орон нутгийн захиргаа болон Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэнтэй нягт уялдаа холбоотой ажиллах, холбогдох мэдээ мэдээллийг цаг тухайд нь хүргэх;

Дөрөв. Гэрээний хэрэгжилт

4.1 Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 02 дугаар сарын 01-ний дотор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлнэ.

4.2. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Тав. Гэрээний хариуцлага

5.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

5.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1 Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

Долоо. Гэрээ хүчин төгөлдөр болох

7.1 Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 /нэг/ жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

7.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байна.

7.4 Гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

СЭЛЭНГЭ АЙМАГ ЕРӨӨ СУМЫН

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА



...../С.ЦЭВЭЛМАА/

АШИГТ МАЛТМАЛЫН
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

"ИНФИНИТИ СПЕЙС" ХХК-ИЙН
ХАНДГАЙТ УУРХАЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



...../Б.ЗОЛЗАЯА/



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН
ЗАСАГ ДАРГА



"ХҮННҮ СТИЙЛ" ХХК-ЫН
ЗАХИРАЛ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2024 оны 07 сарын 03 өдөр

№03

Тавин

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү гэрээг нэг талаас Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг дарга Б.Сэргэлэн (цаашид Засаг дарга гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Хүннүстийл" ХХК (цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Сэлэнгэ аймгийн Ерөө суманд байгуулав.

1.1. Энэхүү гэрээ нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2-р багийн нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших сумын орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

1.3. Энэхүү гэрээ нь Монгол улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Усны тухай, Татварын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд явагдана.

ХОЁР. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. Нутгийн захиргааны байгууллага нь компанийг нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэхэд хуулийн хүрээнд дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажиллана.

2.1.2. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тухай бүрт мэдээлэл өгч, саналыг авах,

2.1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих,

2.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх,

ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1 Үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тавьж шийдвэрлүүлэх,

3.1.2. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаж, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах,

3.1.3. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах,

3.1.4. Онцгой шаардлагатай үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх,

3.1.5. Ерөө сумын Баянголын гүүрнээс 2 даваа хүртэлхи зам засварын ажил хийх

3.1.6. Нийт ажилчдын 60-с дээш хувийг орон нутгийн иргэдээс сонгон шалгаруулж авах

3.1.7. Сумын малчин болон мал бүхий иргэдээс мах махан бүтээгдэхүүн, төмс хүнсний ногоо тариалдаг ААНэгж, иргэдээс төмс хүнсний ногоог тогтмол авах

3.1.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан жил бүр сум орон нутагт тайлагнан дүгнүүлж ажиллах,

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

4.1. Гэрээ 2024 оны 07-р сарын 03-с 2024 оны 12 -р сарын 30-н хүртэл хугацаанд хэрэгжинэ.

4.2 Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 5 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймгийн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөлд хүргүүлнэ.

ТАВ: ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭНД ХЯНАЛТ ТАВИХ, ДҮГНЭХ

5.1. Энэхүү гэрээний биелэлтэнд хяналт тавих үндсэн үүргийг талууд хэрэгжүүлнэ.

5.2 Нутгийн захиргааны байгууллагыг төлөөлөн томилогдсон ажлын хэсэг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний хүрээнд хийсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, шаардлага хангасан ажлыг хүлээн авч, байгууллагын хариуцлагыг өндөржүүлэх,

5.3. Талууд гэрээний биелэлтийг хугацааны эцэст дүгнэж, дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

ЗУРГАА: ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлнэ.

ДОЛОО: МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1.Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

НАЙМ: ГЭРЭЭ ХУЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

8.1 Талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхэлж, тухайн компанийн нийгмийн хариуцлагын гэрээг дүгнэж хэлэлцсэнээр дуусгавар болгоно.

8.2.Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.3. Гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫГ
ТӨЛӨӨЛЖ СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН ГАЗРЫН ДАРГА

..... С.ЦЭВЭЛМАА

Утас:99245745



КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ
“ХҮННҮСТИЙЛ” ХХК-НИЙ
ЗАХИРАЛ

.....О.ГАНЗОРИГ

Утас:99748084

БАТЛАВ
СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН
ЗАСАГ ДАРГА
Б.СЭРГЭЛЭН

БАТЛАВ
“БЭРЛЭГ МАЙНИНГ” ХХК-ЫН
ЗАХИРАЛ
Ш.ЧУЛУУНБААТАР

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2024 оны 04 сарын 22 өдөр

№01

Тавин

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү гэрээг нэг талаас Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг дарга Б.Сэргэлэн (цаашид Засаг дарга гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Бэрлэг майнинг” ХХК (цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2024 оны 04 дугаар сарын 22-ны өдөр Сэлэнгэ аймгийн Ерөө суманд байгуулав.

1.1. Энэхүү гэрээ нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2-р багийн нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших сумын орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

1.3. Энэхүү гэрээ нь Монгол улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Усны тухай, Татварын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд явагдана.

ХОЁР. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. Нутгийн захиргааны байгууллага нь компанийг нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэхэд хуулийн хүрээнд дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажиллана.

2.1.2. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тухай бүрт мэдээлэл өгч, саналыг авах,

2.1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих,

2.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх,

ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1 Үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тавьж шийдвэрлүүлэх,

3.1.2. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаж, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах,

3.1.3. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах,

3.1.4. Онцгой шаардлагатай үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх,

3.1.6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан жил бүр сум орон нутагт тайлагнан дүгнүүлж ажиллах,

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

4.1. Гэрээ 2024 оны 04-р сарын 24-с 2024 оны 12 -р сарын 30-н хүртэл хугацаанд хэрэгжинэ.

4.2 Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 5 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймгийн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөлд хүргүүлнэ.

ТАВ: ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭНД ХЯНАЛТ ТАВИХ, ДҮГНЭХ

5.1. Энэхүү гэрээний биелэлтэнд хяналт тавих үндсэн үүргийг талууд хэрэгжүүлнэ.

5.2 Нутгийн захиргааны байгууллагыг төлөөлөн томилогдсон ажлын хэсэг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний хүрээнд хийсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, шаардлага хангасан ажлыг хүлээн авч, байгууллагын хариуцлагыг өндөржүүлэх,

5.3. Талууд гэрээний биелэлтийг хугацааны эцэст дүгнэж, дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

ЗУРГАА: ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлнэ.

ДОЛОО: МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1.Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

НАЙМ: ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

8.1 Талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхэлж, тухайн компанийн нийгмийн хариуцлагын гэрээг дүгнэж хэлэлцсэнээр дуусгавар болгоно.

8.2.Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.3. Гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫГ
ТӨЛӨӨЛЖ, СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН ГАЗРЫН ДАРГА

..... С.ЦЭВЭЛМАА
Утас:99245745



КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ
“БЭРЛЭГ МАЙНИНГ” ХХК-НИЙ
ЗАХИРАЛ

..... Ш.ЧУЛУУНБААТАР
Утас:99110263

